

ГАРЧИГ

| | | |
|-------|---|-------|
| I. | ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... | 2 |
| | 1.1 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ..... | 2 |
| | 1.2 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР..... | 2 |
| | 1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ, БАЙРШИЛ..... | 2-5 |
| II. | ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... | 6-8 |
| III. | ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ..... | 9 |
| IV. | БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ..... | 10 |
| V. | СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ..... | 12-15 |
| VI. | ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ..... | 17 |
| VII. | ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ..... | 18-20 |
| VIII. | ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ..... | 21-22 |
| IX. | ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР..... | 23-24 |
| X. | УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ..... | 25-26 |
| XI. | ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ..... | 27 |
| XII. | ТӨСӨВ..... | 28 |
| XIII. | ХАВСРАЛТ | |

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төсөл хэрэгжүүлэгч: “БЛАСТТЕК”ХХК

1.2 Улсын бүртгэлийн дугаар: 9011127141

1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Монгол улс, Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, 5-р баг
Хүйх, Үйлдвэр – 1 гудамж, 115а тоот| Утас: 7533-6767

Төслийн байршил.


Сумын Засаг даргын 2022 оны 10-р сарын 13-ний өдрийн А/160 тоот шийдвэрийг үндэслэн Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, 5-р баг Хүйх, Үйлдвэр – 1 гудамж, 115а тоот| хаягт байрлах, нэгж талбарын 2322003619 дугаар бүхий 34185 м.кв газрыг Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-1804000472 дугаарт бүртгэж гэрчилгээ олгогдсон. Төсөл хэрэгжүүлэх газар нь Хэнтий аймаг, Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт Улаанбаатар хотоос зүүн урагш 310 км, Өндөрхаан хотоос баруун урагш 155 км, Дархан сумаас урагш 55 км, Сайншанд хотоос баруун хойш 146 км, Их хэт сумын төвөөс баруун урагш 45 км, Хар Айрагийн төмөр замын өртөөнөөс зүүн хойд зүгт 45 км, Бор-Өндөрийн уурхайчдын хотхоноос зүүн урагш 2.5 км зайд оршдог. Тусгай зөвшөөрлийн талбайн төв нь 1445.7 м үнэмлэхүй өндөртэй Их Бор-Өндөр овооноос ЗХ-45О азимутаар 3.8 км зайд байрлалтай.

Төмөр замын өртөөнүүдийн тухайд Чойр 80 км, Хар-Айраг 55 км зайтай, хамгийн ойр орших төмөр замын 42-р өртөө (Даланжаргалан сум)-аас 45 км зайтай. Эдгээр өртөөнүүд хүртэл ердийн замтай тул жилийн аль ч улиралд саадгүй зорчих боломжтой.

Төслийн хэрэгжих орчмын байрзүйн солбилцол:

| № | X | Y |
|---|---------------|----------------|
| 1 | 46°14'43.81'N | 109°27'37.71'E |
| 2 | 46°14'39.85'N | 109°27'34.65'E |
| 3 | 46°14'43.34'N | 109°27'24.09'E |
| 4 | 46°14'47.36'N | 109°27'27.20'E |

“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн шаардлагын дагуу үйлдвэр нь байнгын их хөдөлгөөнтэй зам, улсын чанартай объект, хүн ам бүхий суурингаас нэг километрийн зайтай байх, бэлэн бүтээгдэхүүн болон түүхий эдээ төмөр зам болон авто замаар тээвэрлэх боломжтой, өндөр хүчдэлийн цахилгаан шугамд холбогдох боломжоор хангагдсан байх шаардлагыг үндэслэн үйлдвэрийн байрлалыг Бор - Өндөр - Даланжаргалан чиглэлийн засмал замаас 3 км, Иргэний нисэхийн ерөнхий газрын харья Бор-Өндөр суман дах Радио локаторын газраас 765 метр, Хиймэл нуураас 1км, Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэрээс 2,9 км, Төмөр замын вокзалаас - 4 км, Төвийн эрчим хүчний шугам 3 км /засмал замтай ижил зайгаар авсан дээрээс харагдахгүй байна/, Ариун - Өндөр баяжуулах үйлдвэрээс 1 км зайд сонгон байгуулсан.



Зураг 1. Төслийн байршил /Google earth/



Зураг 2. Үйлдвэрийн харагдах байдал

Төслийн хүчин чадал

Төсөл хэрэгжүүлэх Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт орших өөрийн эзэмшлийн 3.5 га талбайд Т18 тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын цогцолборын барилга байгууламжийг барьж, ашиглалтад оруулах бэлтгэл хугацааг 2022 оны дөрөвдүгээр улиралд дуусгах ба төсөл хэрэгжих эхний үе шатыг 10 жилээр тооцож байна.

Бүтээгдэхүүн гаргалтын хэмжээг бүс нутгийн зах зээлийн судалгаа, багтаамж, хүлээгдэж буй зах зээлээс хамааран жилд 10,000 тн шингэн эмульсийн тэсрэх бодис, 40,000 тн энгийн тэсрэх бодис, 500,000 ширхэг хэрэгсэл угсарч үйлдвэрлэхээр боловсруулав.

Тэсрэх бодис нийлүүлэх аж ахуйн нэгжүүдийнхээ ажиллах горимд тохируулан жилийн турш тасралтгүй ажиллах бөгөөд үйлдвэрийн процесс нь өдрийн цагаар буюу нэг ээлжээр ажиллана.

Химийн бодисын хэрэглээ.

“БЛАСТТЕК” ХХК нь “МЕРА” ХХК-ний тэсрэх бодис үйлдвэрлэх технологийг ашиглах гэрээгээр тухайн бүс нутгийн зах зээлийн багтаамж, томоохон уурхай, орд эзэмшигчдийн хамтран ажиллах хүсэл, саналд тулгуурлан зүүн болон төвийн бүсийн ил, далд уурхайнууд, зам болон барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компануудыг тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслээр хангах зорилготойгоор барьж байгуулахаар төлөвлөн Т18 тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын цогцолборыг ашиглалтад оруулахаар бэлтгэл болон бүтээн байгуулалтын ажлуудыг хийж байна.

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр нь исэлдүүлэгч усан уусмал бэлтгэх сав /аппарат/ бмз-ийн эзлэхүүнтэй буюу нэг удаад 7.4 тн уусмал бэлтгэх боломжтой бөгөөд усан уусмал бэлтгэх циклийн хугацаа нь ойролцоогоор 4.5-5.5 тонн/цаг байна. Харин эмульсийн матриц бэлтгэх хугацаа нь усан уусмал бэлтгэх циклийн хугацаанаас 3 дахин бага хугацаа зарцуулах юм. Үйлдвэр нь өдрийн 1 ээлж, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг, жилд ажиллах бодит хоног 312 хоногт 6926 тонн шингэн эмульс үйлдвэрлэх бүрэн боломжтой бөгөөд хийжүүлэгч нэмэгдэл болон аммиакийн сэвсгэр шүүний нэмэгдэл 30.2%-ийг оруулан тооцвол дунджаар жилд 10008 тн тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадалтай байхаар байна.

Тус үйлдвэрээс гарах шингэн эмульсийн тэсрэх бодис нь үндсэн 3-н хольцоос бүрдэх бөгөөд эдгээр нь исэлдүүлэгч уусмал буюу усан фаз, тосон фазын холимоогоос үүсэх шингэн эмульс болон сэвсгэржүүлсэн аммиакийн шүү, хийжүүлэгч нэмэгдэл юм. Шингэн эмульс болон хийжүүлэгч нэмэгдлийг үйлдвэрийн орчинд тус тусад нь бэлтгэн тэдгээрийг цооногт цэнэглэх явцдаа хольж дээрээс нь сэвсгэр аммиакийн шүүг нэмэх замаар Fortis Eclipse маркийн шингэн эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэнэ.



Зураг-3. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрлэлт

Агуулахууд

БЛАСТТЕК”ХХК-ийн өдөөгч тэсрэх бодис, савласан эмульсийн тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах зориулалт бүхий байнгын түгээх 4 тн багтаамжтай контейнерийг нийлүүлэн бүлэглэн хийсэн нийт 3 бүлэг 8 хагас далдлагдсан контейнер агуулахыг барьж байгуулсан. Агуулах №1,2,3,4 өдөөгч тэсрэх бодис хадгалах зориулалттай. Агуулах №5,6,7,8 эмульсийн тэсрэх бодис хадгалах зориулалттай. Тэсрэх материалын агуулах нь “Эрдэнэс критикал минералс” ХХК-ийн Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэрийн тэсрэх бодисын агуулахтай зэрэгцүүлэн барьж аюулгүйн зайг нь хамтад нь гаргаж, нэгдсэн хашаа нэгдсэн харуул хамгаалалттай байхаар тооцож хийсэн.

Тэсэлгээний хэрэгслийн агуулахын эргэн тойронд бусад объектууд байрлаж байгаа талд нь нарийн ширхэглэлтэй шороогоор хамгаалалтын далан байгуулсан. Далангийн өндөр нь агуулахын өндрөөс 1.5 метрээс багагүй байхаар төлөвлөж баригдсан. Мөн контейнерын дээвэр хэсгийг бороо цасны ус тогтохооргүй налуутай дээвэртэй байлгах ба доторлогоог үл шатах галд тэсвэртэй материалаар хийсэн байна.

Мөн агуулахын агааржуулалтын системийг агаар чөлөөтэй сэлгэж байхаар бодож тооцоолсон. Тэсэрч дэлбэрэх аюултай бодис хадгалж байгаа тул аянга зайлуулагчийг маш нарийн тооцоололын үндсэн дээр хийж тоногдсон байна. Агуулахын хаалгууд нь бат бэх цоожтой байх ба хаалган хэсгийг бүрэн харахаар хяналтын камерыг байрлуулж мөн гэрэлтүүлгүүд хийгдсэн.



Зураг-4. Тэсрэх материал, түүхий эдийн агуулах

Захиргаа аж ахуйн барилга

Тоосгон байшинг засварлан ажилчдын түр байрлах байр болгон ашигласан. Хагас арк хэлбэрийн ангорон, угсардаг эмульсийн тэсрэх бодисын үл тэсрэх хольцийн T18 үйлдвэрийн барилга. Энэхүү барилгад тус лабораторийн хэсэг бүхэлдээ байршина. Хагас арк хэлбэрийн ангорон гараж угсарсан. Агуулахын 8 контейнер, түлшний колонк, 2 ш харуулын цамхаг барьсан.

Мөн үйлдвэрийн байр, гараж, бэлэн бүтээгдэхүүний болон түүхий эдийн агуулах, оффисын барилга, харуулын байр зэрэг шаардлагатай газруудад 32 ширхэг хяналтын камер байрлуулан 24 цагийн турш хянаж байна.



Зураг 5. Үйлдвэр болон гараж барилгын харагдах байдал

Үйлдвэрийн лаборатори

Үйлдвэрийн түүхий эд бүтээгдэхүүний чанарын хяналтыг үйлдвэрийн лабораториор хянаж ажилладаг ба тоноглож байгуулсан туршилтын талбайд бүтээгдэхүүний туршилтын ажлыг мэргэжлийн эрх бүхий үнэмлэхтэй тэсэлгээчид гүйцэтгэдэг.



Зураг 6. Үйлдвэрийн хяналтын лаборатори

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүй:

Бор-өндөр сумын төв орчим нь физик газарзүйн хувьд Говийн их мужийн Дорнод говийн мужийн Умард говийн гүвээт талын тойрогт багтана. Газрын гадаргын бүтцийн хувьд Алтайн нурууны өмнөх болон ар говиос ялгаатай, харин Монголын Дорнод талтай төстэй, энд тэнд ганц нэгээрээ буюу хэсэг бүлгээрээ товойн харагдах толгод бүхий ухаа гүвээт тал элбэг тохиолдоно. Дорнод говийн муж нь гадаргын хувьд ухаа гүвээт тал, цав толгод, хотгор нам газар гол суурийг эзлэх бөгөөд говийн зүүн хэсэгт байгаа уулс харьцангуй намхан, өндөр нь 1500-2000 метрээс үл хэтэрнэ.

Цаг уур, уур амьсгал:

Уур амьсгалын үндсэн нөхцөл нь эх газрын эрс тэс цаг агаарын шинжтэй, хот орчмын бичил, бэсрэг уур амьсгалын онцлогтой. Налайх орчмын агаарын температур өвөл 18.80 - 22.70, зун 12.80 - 15.40, Жилд унах тунадасны хэмжээ 260-290 мм, жилийн дундаж агаарын даралт 852.3 гПа, дундаж салхины хурд жилд 4.2 м/с байна. Хэнтий аймгийн Бор-өндөр сум нь нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг. Төлөвлөж буй төслийн талбайн бүс нутаг нь уур амьсгалын эх газрын эрс тэс шинжтэй. Энд өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжилнэ. Зун нь богино, халуун болдог. Хавар, намрын улиралд цаг агаар тогтворгүй эрс өөрчлөгдөж байдаг.

Төслийн бүс нутгууд нь уур амьсгалын мужлалаараа эх газрын эрс тэс уур амьсгалын бүсэд ордог. Жилийн хамгийн их хүйтрэлт 1-р сард -24...-29 0C хүрч хүйтэрдэг бол харин 3-р улиралд хамгийн их дулаарах ба 7-р сард дунджаар +27...+32 0C градус хүрч халдаг байна. Хүйтний улирал жил бүрийн 10-р сарын сүүлч 11-р сарын эхээр эхлэх ба 3-р сарын дунд үеэс дулаарна. Төслийн бүс нутгуудаар жилд дунджаар 80.5-112.1 мм тунадас унах

бөгөөд ихэнх (80-90%) хэсэг нь 6-8 сард ордог. Өвлийн улиралд цасан бүрхүүлийн зузаан 40 мм-ээс хэтрэхгүй. Хөрсний улирлын хөлдөлт хөрсний 2.0 м гүнд хүрдэг. Шилжилтийн улиралд хавар, намрын саруудад хүчтэй салхи, шороон шуурга ажиглагдах нь сүүлийн жилүүдэд ихсэх хандлагатай байна.

Гадаргын болон газар доорхи ус:

Төсөл орчмын талбай нь усзүйн хувьд газар доорх усны нөөц зонхилсон “Умард говийн гүвээт халхын дундад тал” сав газар блон Хэрлэн голын ай сав газрын зааг дээр оршдог. Энэхүү сав газарт ашиглах бололцоотой газар доорх усны нөөц гэдэг нь олон жилийн туршид хуримтлагдсан нөхөн тэжээгдэггүй газар доорх усны нөөцөөс бүрддэг гидрогеологийн мужлалын III эрэмбийн гидрогеологийн массивд хуримлагдсан ба үндсэндээ Монгол орны хээрийн бүсэд оршдог учраас энд жилд унах тунадас багавтар бөгөөд ууршилт нь унах хур тунадасаас даруй давдаг байна. Өөрөөр хэлбэл, энд гадаргын ус багатай бөгөөд ихэвчлэн гүний газар доорх ус тархсан байдаг.

Хөрс, ургамал, амьтан:

Хөрс газарзүйн мужлалаар авч үзвэл Хархүрэн хөрсний дэд муж, Бор-Өндөр Уулбаяны тойрогт хамрагддаг. Судалгааны бүс нутаг нь хээрийн бүсэд байрлах учир Хархүрэн хөрс тэр дундаа чулуурхаг нимгэн ба сайргархаг элсэнцэр хөрсний төрлүүд, дангаар болон бүрдэл байдлаар тархсан байна. Төслийн талбайн дундаж өндөржилт нь далайн түвшнээс дээш 1269-1270 м орших бөгөөд өнөөгийн байдлаар орон нутгийн чанартай зориулалттай ердийн замын нөлөөгөөр хөрсөн бүрхэвчид тодорхой хэмжээний нөлөөлөл үзүүлсэн байна. Төслийн талбайд чулуурхаг чулуурхаг элсэнцэр Хархүрэн хөрс 56%, сайргархаг элсэнцэр Хархүрэн хөрс 30.5%, ердийн шороон замаар талхагдсан хөрс 13.5% тус тус тархсан байна (Зураг 10). Чулуурхаг хөрс нь гадаргын үл мэдэг өндөрлөг хэсгээр, сайргархаг ба элсэнцэр төрлийн хөрс нь үл мэдэг хотгордуу буюу хуримтлал үүсэх боломжтой газарт тус тус тархаж байна. Хархүрэн хэвшинжийн хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин дунд зэрэг, машин техникийн хөдөлгөөн гэх мэт хөрсний гадаргад үүсэх механик нөлөөллөөр амархан эвдэрч талхагдахгүй, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж дунд зэрэг буюу хөрсний бүтцийн тогтворшилт дунд ангилалд ордог. Ингээд төслийн талбайд зонхилон тархсан хөрсний төрлүүдийн гадаргын ба үе давхаргын морфологи шинж чанар болон хөрсний үржил шим ба хими физик шинж чанарын талаар дараах хэсгүүдэд дэлгэрэнгүй орууллаа.

Энэ газар нутаг нь ургамал газарзүйн мужлалын хувьд Евро-азийн хээрийн их муж Дагуур-Монголын дэд их муж Говийн умард-Дорнод хамаарна.(Үндэсний атлас, 1990). Бэлчээрийн ургамлан нөмрөгт судалгаа хийж, газрын төлөв байдал, ургамалжлын хэв шинжүүдийг тогтоох бичиглэл хийсэн. Төслийн талбайн геоморфологийн мужлалтаар нь Төв азийн геоморфологийн их муж, дэд муж Дундговьд хамаарна. Газрын гадаргуу нь тэгширсэн газар,уулан дундах хотгор дахь бүтэц ул чулуулаг дээрх элэгдлийн суурьт тал толгодот, хөндийн ёроолоор, татмын нам дэнж үргэлжилнэ.

- Төслийн талбай орчимд бэлчээрийн ургамлын судалгаа гүйцэтгэхэд нийт 14 овгийн 33 төрлийн 39 зүйл ургамал тэмдэглэгдсэн.
- Зүйлийн бүрэлдэхүүн дэх ургамлууд нь амьдралын хэлбэрийн хувьд сөөг-2, сөөгөнцөр-олон наст зүйл- 26, нэг наст- 11 зүйл ургамал тус тус тэмдэглэгдсэн. Зүйлийн бүрэлдэхүүний сөөг 5%, олон наст 67%, нэг ба хоёр наст 28% зэрэг ургамлууд бүрдүүлж байна.

Төсөл хэрэгжих газар нутаг орчмын амьтны аймгийн онцлог, амьтны аймаг, тэдгээрийн амьдрах орчинд төслийн зүгээс нөлөөлөх байдлыг тодруулахад тухайн талбайд тархсан ховор, нэн ховор, устаж байгаа, эмзэг зүйлүүд байгаа эсэх, амьдрах орчин нөхцөлийн эмзэг байдал, сэргэх чадвар болон хамгаалалтад авсан эсэх нь голлох үүрэгтэй. Монгол орны ховордсон ба ховордож устаж болзошгүй ургамал, амьтны төрөл зүйлүүдийг бүртгэн багтаасан Улаан номыг 1987, 1997, 2014 онуудад хэвлэн гаргасан билээ. Мөн Дэлхийн байгаль хамгаалах хорооны (ДБХХ) амьтны ховордлын зэргийн улаан жагсаалтаар ховордож болзошгүй, эмзэг, устаж болзошгүй гэж ангилагдсан амьтдаас төлөвлөж буй төслийн талбай орчимд дараах амьтад тархсан байна:

- Аргаль
- Янгир ямаа
- Цагаан зээр

Нийгэм-эдийн засаг,

Хэнтий аймгийн Бор-Өндөр сум нь 1981 онд Хэрлэн хороо гэж байгуулагдаж, газар нутгийн харьяалал нь хуучнаар Хэнтий аймгийн Дархан сумын 5-р баг байсан. УИХ-ын 2012 оны 02 сарын 09 ний өдрийн 15-р тогтоолоор Бор-Өндөр сум болон өөрчлөгдөж, 2012 оны 12 дугаар сараас эхлэн сумын бүтэц зохион байгуулалтад орсон. 1-р баг /Бор-Өндөр/, 2-р баг /Холбоо/, 3-р баг /Бумбат/, 4 р баг /Уурхайчин/, 5-р баг /Хүйх/, 6-р баг /Өлгий/ гэсэн 6 багийн нийт 2660 өрх, 8883 хүн амтай.

Хүн амын тоогоор Хэнтий аймгийн 18 сумаас эхнээсээ 1-д, газар нутгийн хэмжээгээр 18-д ордог /аймгийн төвийг оролцуулалгүйгээр/ хүн амын нягтралаар хамгийн өндөр 60,99 хүн/га сум юм. 2017 оны байдлаар 8883 хүн тоологдсон ба үүнээс эрэгтэй 4442, эмэгтэй 4441. Нийт хүн амын 99.63 хувийг Халх ястан, 0.12 хувийг Казах ястан, 0.25 хувийг Дөрвөд ястан эзлэн амьдарч байна. Бор-Өндөр орчмын сумдын нутаг дэвсгэрийн өнөөгийн судалгаанд тулгуурлан ашигт малтмалын ордыг ашиглан уул уурхайн үйлдвэрлэл, мал аж ахуйн түүхий эдэд түшиглэн малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, түүхэн дурсгалт газрууд, амралт рашаан сувилалд тулгуурласан дотоод гадаадын аялал жуулчлалыг хөгжүүлэн тойргийн сумдын эдийн засагт нөлөөлөхүйц бичил бүсийн төв болгон хөгжүүлэх хэтийн төлөв байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Химийн бодис ашиглах, хадгалах, тээвэрлэх явцад агаарын бохирдлын гол эх үүсвэр нь химийн бодис зөөж тээвэрлэх тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтын хий болон замаас үүсэх тоосжилт байна. Үйл ажиллагааны улмаас орчны хөрс эвдэрч тоосжилт нэмэгдэх, химийн бодис уусмалыг тээвэрлэх, ачих,буулгах,зөөх,хадгалах үеийн ууршилтаас гарах хий, хатуу бодисын тоос нь яг агаарын чанарт нөлөөлөх боловч хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан ажилласнаар энэхүү нөлөөллийг багасгах боломжтой. Химийн бодисын сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавих, химийн бодисын алдагдал, ууршилт гарахаас сэргийлэх, ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, агуулахад агааржуулалтын төхөөрөмж тавих, ажлын байрны агаар дахь химийн хорт бодисын агууламжийг тогтмол хянах шаардлагатай.

3.2 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээ

Хэнтий аймгийн аймгийн Бор-Өндөр сумын нутагт баригдах “Бласттек”ХХК-ийн тэсрэх бодисын үйлвэрийн талбайн хөрс нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар авч үзвэл Хархүрэн хөрсний дэд муж, Бор-Өндөр Уулбаяны тойрогт хамрагддаг. Судалгааны бүс нутаг нь хээрийн бүсэд хэрэгжих учир Хархүрэн хөрс тэр дундаа чулуурхаг нимгэн ба сайргархаг элсэнцэр хөрсний төрлүүд, дангаар болон бүрдэл байдлаар тархсан байна.

3.3 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл

Төслийн талбай орчмын усны хяналт шинжилгээгээр байгаль орчны төлөв байдлын хээрийн судалгааны ажлын хүрээнд Бор-Өндөр сумын төвийн худаг, хээрийн задгай горхи, уурхайн шүүсэн саарал ус зэрэг 4 газраас усны дээж авч Шинжлэх ухааны акедамын Газарзүй-Геозкологийн хүрээлэн усны шинжилгээний лабораторид шинжлүүлсэн.

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонтын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуулаг дотроо магнийн ион зонхилсон, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь” Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018”-н шаардлага хангаж байна.

Түүхий эд болон бэлэн болсон бүтээгдэхүүнийг ачиж буулгах, тээвэрлэх явцад хөрс элэгдэх, эвдрэх, агаарт тоос дэгдэх, хог хаягдал, түүхий эдийг ил задгай хаяснаас хөрсний бохирдол үүсэх, автомашины хөдөлгөөнөөс үүдэн зам орчмын ургамлан бүрхэвчид нарийн ширхэгт тоос тогтож улмаар ургалтад нь сөргөөр нөлөөлөх зэргээр үйлдвэр агуулахын цогцолбор төслөөс байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх боломжтой байдаг.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

Байгууллагын зорилго болон төлөв байдал, үйл ажиллагаа явуулж байгаа хүрээлэн буй орчны нөхцөл байдлыг анхааран авч үзсэнээр “Бласттек” ХХК-ийн удирдагууд нь нийцлийн үүргийнхээ дагуу ISO 14001:2015 стандартын зарчим болон шаардлагуудыг даган мөрдөж Байгаль орчин (БО)-ны удирдлагын тогтолцоог байнга сайжруулж хэрэгжүүлнэ.

Бид хүрээлэн буй орчны бохирдлоос урьдчилан сэргийлж, гарах сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

- “БЛАСТТЕК” ХХК нь энгийн тэсрэх бодис, задгай болон савласан эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн бага түвшинд байлгахыг 2026 онд зорилт болгон ажиллаж байна.
- Монгол улсын Үндсэн хууль болон бусад байгаль орчинтой холбоотой хууль, дүрэм журам, стандартуудын хүрээнд үйл ажиллагаа явуулах.
- Байгалийн нөөц баялгийг ариг гамтай ашиглаж, үйл ажиллагаанаас бий болсон хоёрдогч түүхий эд, материалыг зүй зохистой ашиглах ба дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- Сум орон нутгийн байгууллагатай байгаль орчин нийгмийн хүрээнд хамтран ажиллаж, төслийн үйл ажиллагааг нээлттэй байлгах.
- Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний сайжруулалтыг хийж, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг тодорхойлох.
- Үйл ажиллагааны процессуудын эрсдэлийн тодорхойлж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах хэмжээ | Арга хэмжээ цар хүрээ | Нэгжийн зардал /сая, төг/ | Хугацаа давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|----------|--|---|--|----------------------------------|------------------------------|---|
| 1 | Дотоод болон гадаад орчны агаарын бохирдол | Үйлдвэрийн дотоод орчны агаарын чанарыг хэмжих | Үйлдвэрийн байр дотор /хяналтын өрөөнд-1, химийн бодис буулгах хэсэгт-1 Үйлвэрийн хэсэг дотор-1 | 1,5 сая | Төсөл хэрэгжих хугацаанд | MNS 5010-2001 Тоос. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 4585:2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага, MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээний арга, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 |
| 2 | | T18 үйлдвэрийг барихдаа ажиллах орчны агаарын чанарын урсгалыг сайжруулах | Төслийн барилга байгууламж | Дотоод хяналтаар | Жил бүр | |
| 3 | | Ажлын байр, агуулах, барилгуудын агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг хангах | Төслийн барилга байгууламж | 2,5 сая төгрөг | Үйлдвэр ашиглалтад орсон үед | |
| 4 | | Төсөл орчмоос гарч байгаа дуу чимээг стандартын түвшинд байлгах, давсан тохиолдолд эх үүсвэрийг тодорхойлж, багасгах арга хэмжээг авах | Төслийн хэмжээнд | Дотоод зардлаар | Жил бүр | |
| 5 | | Тэсэлгээний бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд, зориулалтын сав баглаа боодол, контейнерт хадгалах | Тэсрэх бодисын агуулах | Дотоод төлөвлөлтөөр | Жил бүр | |

| | | | | | | |
|--|---|--|------------------|--------------------------|--------------------------------------|--|
| 6 | Автомашин, техникийн хөдөлгүүрээс үүсэх хийн бохирдол | Бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээ хийх | Төслийн хэмжээнд | Дотоод хяналтаар | Тогтмол | MNS 0017-5-1-21: 1992 Дуу чимээ, авто тээврийн хэрэгслийн дуу чимээний хүлцэх төвшин, хэмжих арга |
| Гадаргын болон газрын доорхи ус, усны чанар | | | | | | |
| 1 | Барилга барих бараа материалын тээвэр хийх хүнд машин механизмын хөдөлгөөнөөр үүссэн бохирдол болон хог хаягдал нь үерийн усаар зөөгдөх | Ахуйн хуурай хог хаягдлын цэг болон шингэн хаягдлыг зайлуулах цэг, машин техникийн зогсоол зэргийг жалга, суваг шуудуунаас хол зайд байрлуулах | Төслийн талбайд | Үйл ажиллагааны зардлаар | Тогтмол | Байгаль орчныг хамгаалах тухай хууль MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. MNS 5667-2:2001 Усны чанар – Дээж авах – 2 -р бүлэг Дээж авах арга MNS 4867:1999 Усны чанар – Дээж авах арга – 3- р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга. |
| 2 | Тэсэлгээний хорт болон аюултай бодисыг хүлээн авах, тээвэрлэх, хадгалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс бодис алдагдаж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах | | Төслийн хэмжээнд | Ерөнхий төлөвлөлтөөр | Үйлдвэр баригдах эхний жилд хийгдсэн | |

| | | | | | | |
|--|--|---|------------------|---|---------|--|
| | Үйлдвэр, ахуйн бохир ус алдагдаж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах | Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжид тушаах | Үйлдвэрийн оффис | - | Жил бүр | |
|--|--|---|------------------|---|---------|--|

| ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ | | | | | | |
|---|---|---|--------------------|---------------------|---------------------------------|---|
| 1 | Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн доройтол | Хөрсний дээж авч мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлэх | Үйлдвэрийн талбайд | ОХШХ -т тусгав | Жилд 1-2 удаа (70,000 мян, төг) | Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019 |
| 2 | | Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны ажлыг хуулинд заасан хугацаанд хийлгэх | Бласттек ХХК | Дотоод төлөвлөлтөөр | 5 жилд нэг удаа | Газрын тухай хуулийн 58 -р зүйл Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам |
| 3 | Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх | Замын тоосжилт бууруулах зорилгоор зам засвар аричилгаа хийх | Төслийн хэмжээнд | Дотоод төлөвлөлтөөр | Жил бүр 2 удаа | MNS 4597:2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм |
| 4 | | | Төслийн хэмжээнд | Дотоод зардлаар | Тогтмол | |

| | | | | | | |
|---|---|---|---|--|--|--|
| 5 | Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг ил задгай хаяснаар хөрс бохирдох | Хог хаягдлын менежмент төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажиллах | БЛАСТТЕК ХХК | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав. | Төсөл хэрэгжих хугацаанд | Хог хаягдлын тухай хууль |
| 6 | | Хог хаягдлын сав, цэгийн тохижуулах | Төслийн хэмжээнд | Дотоод төлөвлөлтөөр | Жил бүр улирал тутам | |
| 7 | Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглахтай холбогдох гарах нөлөөлөл | Бүх төрлийн химийн бодис, шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй, үер усанд автагдахааргүй нөхцөлд хадгалах | Төслийн хэмжээнд | - | Үйл ажиллагааны туршид | “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” Монгол улсын шадар сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 54/А/136/А125 дугаар хамтарсан тушаал |
| 8 | | Тэсэлгээний бодис, материал хүлээн авах талбай, агуулах, үйлдвэрийн барилга байгууламж, шал зэрэгт байнгын үзлэг шалгалт хийж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд дор нь засварлах | Төслийн хүрээнд | - | Өдөр тутмын үйл ажиллагаанд | |
| УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ | | | | | | |
| 1 | Хүний эрүүл мэндэд нөлөөлөх | Ажилчдыг тусгай хувцас хэрэгслээр бүрэн хангах | Химийн бодистой харьцаж ажилладаг бүх ажилчид | Дотоод зардлаар | Ажилтан бүрийг тусгай хувцас хэрэгслээр тогтмол хангах | <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй |
| 2 | | Ажилчдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн | | | Жилд 1 удаа | |

| | | | | | | |
|--|---|--|--|-----|---|--|
| | | урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | | | | ажиллагааны ерөнхий шаардлага MNS 4992:2000 - Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага. MNS (ISO) 13688:2000 Гал түймрээс хамгаалах. MNS 5566-2005 |
| 3 | | Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах | | | Үйл ажиллагааны туршид | |
| 4 | Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл | Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах | Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр | - | 2 жил тутамд нэг удаа | Галын аюулгүй байдлын тухай хууль Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам |
| 5 | | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд дүгнэлт гаргуулах | Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр | - | Жилд 1 удаа | Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаал, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам |
| 6 | | Үйлдвэр баригдсан дараа 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэх | Тэсрэх бодисын үйлдвэр төслийн хүрээнд | 8.0 | 2 жил тутамд 1 удаа байгаль орчны аудит хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. | Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 -р зүйл |
| СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ /сая. төг./ | | | 12 сая, төгрөг | | | |

ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Ногоон байгууламжийн зорилт | Ногоон байгууламжийн арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (сая. төг) | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн бичиг баримт |
|--|--|----------------------------------|---|---|---------------------------|-------------------------------|---|
| 1 | Тэсрэх бодисын үйлдвэрийн тэсэлгээний ажлын нэгдсэн дүрмийн дагуу эзэмшил талбайд ногоон байгууламж байгуулах боломжгүй. Тиймээс өөр газар дүйцүүлэх мод тарина. | Мод тарих /Агч/ | Бор – Өндөр сумын орон нутгийн байгууллагатай хамтран мод тарих газар сонгох Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 1 га талбайд мод тарих | 1 га-д тарих модны тоо хэмжээ 3000 ш суулгац Тарихаас 2026 онд 1500 ш мод тариалалт хийнэ. | 9,000,000 | Жилд 2,5 га | Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаарлдага MNS 5918:2008 Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4 -р зүйл |
| НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДЛЫН ДҮН | | | | | | 2026 онд 9 сая, төгрөг | |

ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал (төгрөг) | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн бичиг баримт |
|--------------------|---|--|-----------------------------------|-------------------|--------------------------------|-------------------------|-------------------------------------|--|
| 1 | Тэсрэх бодисын үйлдвэр нь газрын хэвлий ухах, ашигт малтмалын үйл ажиллагаа явуулахгүй тул түүх, соёлын өвд олдох, өртөхгүй | Төслийн талбайн хэмжээнд түүх соёлын өв олдсон тохиолдолд орон нутгийн төрийн байгууллагатай хамтран ажиллах | Төслийн хэмжээнд | - | Дотоод зардлаар | Дотоод зардлаар | Тайлант хугацаанд | Соёлын өвийг хамгаалах тухай хууль |
| Нийт зардал | | | | | | ₮ 0.00 | | |

НАЙМ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн зардал (төгрөг) | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн бичиг баримт |
|---|---|---|--|---------------------------------|------------------|---|--|
| 1 | Хөрс, болон усан орчинд химийн болон тэсэлгээний бодис асгарч, алдагдах | Ажилтнуудыг химийн бодисын хор аюул, түүнтэй хэрхэн харьцах, асгарч, алдагдсан үед авах арга хэмжээ, хувийн хамгаалах хэрэгсэл, анхны тусламж, галын аюулын үед авах арга хэмжээний талаар сургалтанд хамруулах | Тэсрэх бодисын үйлдвэрийн нийт ажилтнууд | Дотоод зардлаар | | Жилд 2 удаа | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011 |
| 2 | | Битүү болон задгай агуулахын шалыг зай завсаргүй бетондсон байх, химийн бодист тэсвэртэй эпокси будгаар будах | Төслийн хүрээнд | 1.0 | Хийгдсэн. | Эхний жилд | Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014 |
| 3 | Химийн бодисын битүүмж алдагдах | Химийн бодисын сав баглаа боодлыг тогтмол шалгах | Төслийн хүрээнд | - | | Шатамхай, онцгой хортой бодисын сав баглаа боодлыг өдөрт 1 удаа, бусад бодисын 7 хоногт 1 удаа шалгах | Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам – Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 54/А/136/А/125 дугаар хамтарсан тушаал. |
| 4 | Хортой хий хуримтлагдах | Агааржуулалтын системийн засвар үйлчилгээг тогтмол хийх | Төслийн хүрээнд | Үйл ажиллагааны дотоод зардлаар | | Үйл ажиллагааны явцад тогтмол хийх | Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014 |

| | | | | | | |
|---|---|---|--|---------------------------------|----------|--|
| 5 | Техник хэрэгсэлтэй харьцах үед гарч болзошгүй осол аваар | Тоног төхөөрөмжийн операторыг химийн бодисын хор аюул, түүнтэй хэрхэн харьцах, анхны тусламж, хамгаалах хэрэгсэл, галын аюулын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон сэрээт өргөгчийг аюулгүй ажиллуулах сургалтанд хамруулах | Төслийн хэмжээнд | Үйл ажиллагааны дотоод зардлаар | | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011 |
| | | Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах | | | | - |
| 6 | Санамсаргүй байдлаас химийн бодисын бүрэн бүтэн байдал алдагдаж асгарах | Химийн бодисын сав баглаа боодол битүүмжийг тогтмол шалгах | Үйлдвэрийн хэмжээнд | - | Өдөр бүр | Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам - Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 54/А/136/А/125 дугаар хамтарсан тушаал. |
| 7 | | Химийн бодистой харьцан ажилладаг ажилчдад зааварчилгаа өгөх | Үйлдвэрийн химийн бодистой харьцаж ажилладаг бүх ажилчид | - | Өдөр бүр | |

ГАЛ ТҮЙМЭР

| | | | | | | | |
|---|--|--|---------------------|---------------------|---|-------------------------------------|---|
| 1 | Гал түймэр | Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах | Үйлдвэрийн хэмжээнд | 0.9 | 4.5 | Үйл ажиллагааны туршид | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011 |
| 2 | Тээврийн хэрэгслийн яндангаас оч хаях | Тээврийн хэрэгслийн янданд оч баригч суурилуулах | Төслийн хүрээнд | Дотоод төлөвлөлтөөр | | Эхний жилд суурилуулсан | Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах шаардлага MNS 5029:2011 |
| 3 | Шатамхай болон исэлдүүлэгч бодисыг хамт хадгалах | Хор аюулыг лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгалах | Төслийн хүрээнд | - | - | Үйл ажиллагааны туршид тогтмол хийх | Химийн бодис тус бүрийн аюулгүйн лавлах мэдээлэл |
| ҮЕР УС | | | | | | | |
| 1 | Химийн бодис үерийн усанд норох | Химийн бодисыг усанд норохоос хамгаалж, агуулахын шалан дээр нэмэлт суурь тавих | Төслийн хүрээнд | 1.0 | 1.0 | Эхний жилд нэмэлт суурь тавигдсан | Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014 |
| ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ | | | | | 2026 оны нийт зардал: 1.9 сая. төг | | |
| ЗАРДАЛ /сая. төг/ | | | | | | | |

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Нэгжийн зардал (төгрөг) | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн бичиг баримт |
|---|---|---|--|-------------------------|------------------|------------------------------------|---|
| 1 | Үйлдвэр баригдах үед үүсэх | Үйлдвэр баригдах үед барилгын хог хаягдал, ахуйн хог хаягдал үүсэхээс сэргийлж хогийн сав байрлуулах | Үйлдвэрийн хэмжээнд | - | | Жил бүр | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар тушаал |
| 2 | Хөрс, ус, агаарын бохирдол. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл | Үйлдвэрийн үйл ажиллагаа эхэлсний дараа ашигласан химийн бодисын сав баглаа боодлыг ашиглалтын дараа цуглуулж химийн бодис нийлүүлэгчид буцаан тушаах эсхүл эрх бүхий байгууллагын удирдамжийн дагуу аюулгүй газарт хадгалах. | Ашигласан материалын уут, сав, олгой, таар, шуудай гэх мэт | - | 3.0 | Жил бүр | Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. MNS 6458:2014 |
| | | Химийн бодисын сав баглаа, хаягдлын их хэмжээгээр хуримтлуулж удаан хугацаагаар хадгалахгүй байх, үйлдвэрээс зохих журмын дагуу материалыг бүрдүүлж хаягдлыг устгуулах тухай хүсэлтийг гаргаж байх. | “БЛАСТТЕК” ХХК -ийн хэмжээнд | - | - | Үйл ажиллагаа эрхлэх бүх хугацаанд | “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, устгах журам”- Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 54/А/136/А/125 дугаар хамтарсан тушаал |

| | | | | | | | |
|---|--|---|--|---|--------------------------------------|-------------|--|
| | | Ажилчдын хог хаягдлын хууль эрхзүйн орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах | | - | 0.5 | Жилд 2 удаа | |
| ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ /сая. төг/ | | | | | 2026 оны зардал: 3.5 сая. төг | | |

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Хяналт шинжилгээний ажлын хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Баримтлах стандарт, арга аргачлал |
|-----------------------------|--|---|-----------------------|---|--|------------------|---|
| Агаарын чанар | | | | | | | |
| 1 | -Хүхэрлэг хий (SO ₂) -Азотын ислүүд (NO _x) - PM 2,5 - PM 10 -TSP нийт тоос - Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) | 1. T18 үйлдвэр 2. Оффисын орчим 3. Химийн бодисын агуулахын орчим | Жилд нэг удаа, 9 сард | Гадаад орчны шинжилгээнд 2026 онд 3 цэгт шинжилгээ хийж эхэлнэ. | Нэг удаа: 41.0 Нийт 3 цэгт*1 удаа = 123.0 | 0,123 | 5 жилд 0,615 MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодисэлементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага. MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга |
| Хөрсний төлөв байдал, чанар | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|--|------------------------------|---|-------------------------------------|--------------|------------|---|--|
| 1 | <p>-Хөрсний орчин -Ялзмагийн агууламж мг/кг -Карбонатын агууламж - Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн -Хүнд металлын агууламж - Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)</p> | <p>1. T18 үйлдвэр 2. Химийн бодисын агуулах 3. Хогийн цэг 4. Дизель түлш хадгалах цэг</p> | <p>Жилд нэг удаа, 6 сард</p> | <p>Нэг удаагийн шинжилгээнд мониторингийн 4 цэгээс дээж авч шинжлүүлнэ.</p> | <p>Нэг удаа: цэгт*110.0 = 440.0</p> | <p>0,440</p> | <p>2,2</p> | <p>MNS 3307:1991, MNS 3308:1991. Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга MNS 3309: 1991 Хөрс, Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга MNS 3675: 1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачиганы арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS: ISO 11047: 2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675: 1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторын арга</p> | |
| | Усны чанар | | | | | | | | |
| | <p>-Усны орчин рН - Эрсдлийн бүрэлдэхүүн -Хүнд металлын агууламж -Микробиологи</p> | <p>1. Унд ахуйд хэрэглэх ус 2. Төслийн талбайгаас хойш 500 м – т хэрэгжих хээрийн задгай горхи</p> | <p>Жилд 1 удаа, 9 сард</p> | <p>Нэг удаагийн шинжилгээнд мониторингийн 2 цэгээс дээж авч шинжлүүлнэ</p> | <p>2 дээж*50.0=100.0 төг</p> | <p>0,100</p> | <p>0,5</p> | <p>MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900: 018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт.</p> | |
| ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН /сая.төг/ | | | | | | | | 2026 оны зардал: 1 сая.төг | |

**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|----------|--|--------------------------------|----------------------------|--|--|
| 1 | Сум орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулж байгаль орчныг хамгаалах чиглэлийн ажилд хамтран ажиллах | Дотоод зардлаар | 2026 онд | Үйлдвэрийн инженер, ХАБ, БО-ны мэргэжилтэн | Сум орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулан, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд хамтран ажиллах |
| 2 | Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах | Дотоод зардлаар | Сард 2 удаа | Үйлдвэрийн инженер, ХАБ, БО-ны мэргэжилтэн | Бүх нийтийн цэвэрлэгээ тогтмол зохион байгуулж төслийн талбай орчмыг цэвэр, аюулгүй байлгах |
| 3 | Байгаль орчныг хамгаалах чиглэлээр, ажилчдын дунд сургалт семинарыг улиралд нэг удаа тогтмол зохион байгуулах | Дотоод зардлаар | Улиралд 2 удаа | Үйлдвэрийн инженер, ХАБ, БО-ны мэргэжилтэн | Байгаль орчны чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаа болон ажилчдын оролцоо, хариуцлагын талаар сургалт зохион байгуулах |
| 4 | Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх | Гүйцэтгэлээр | 2026 онд | Үйлдвэрийн инженер, ХАБ, БО-ны мэргэжилтэн | Хэнтий аймгийн ЗДТГ гаргасан санал хүсэлтийг гэрээний дагуу харилцан шийдвэрлэх |
| 5 | Болзошгүй осол, гал унтраах хэрэгслээр байгууллагыг бүрэн хангах арга хэмжээ авах, гал унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах | Гүйцэтгэлээр | 2026 онд | Үйлдвэрийн инженер, ХАБ, БО-ны мэргэжилтэн | Төслийн хэмжээнд ашиглагдаж буй гал унтраагуур болон иж бүрдлийг тогтмол хянан шалгаж шаардлагатай тохиолдолд шинэчлэх. Галын аюулгүй байдал болон гамшгийн бэлэн байдлын сургалт зохион байгуулах |

| | | | | | |
|--------------------|---|----------------------------------|----------|--|---|
| 6 | Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй бусад зардал | Хөрөнгө оруулалтаар | 2026 онд | Үйлдвэрийн инженер, ХАБ, БО-ны мэргэжилтэн | Төслийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй бусал үйл ажиллагааны зардлууд |
| 7 | Компанийн үйл ажиллагаа, БО хамгаалах талаар мэдээллээр хангах /сум орон нутаг/ | - | 2026 онд | Үйлдвэрийн инженер, ХАБ, БО-ны мэргэжилтэн | Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдэж буй ажиллагааны талаар тогмтол мэдээллээр хангах |
| Нийт зардал | | Үйл ажиллагааны зардалаар | | | |


**АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах ороцлогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, төг | Зохион байгуулах газар |
|-----------------------|--|-----------------------------------|--|---------------------------------------|------------------------------|-------------------------------|
| 1 | Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын ИНХ-аар Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээг танилцуулах | Нээлттэй өдөрлөг зохион байгуулна | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хэрэгжилт, бусад ажлуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх | 2026 оны 10-р сар | 1,000,000 | БЛАСТТЕК ХХК |
| 2 | Хэнтий аймгийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь үзэж шалгах ажлын хэсгийн үзлэг шалгалт | Шалгалтын дүн | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гүйцэтгэл | 2026 оны 11 сар | - | |
| 3 | Хэнтий аймгийн БОАЖГ-т Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан хүргүүлэх | Албан бичгээр | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гүйцэтгэл | 2026 оны 11 сар | - | |
| 4 | Байгаль орчны чиглэлээр хийгдэж буй ажлуудыг олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд танилцуулах | Цахим мэдээллийн хэрэгсэл | Байгаль орчны чиглэлээр хийгдсэн онцлох ажлууд | 2026 он | - | |
| Нийт 1,000,000 | | | | | | |

ХИШ. ЖИЛИЙН НИЙТ ТӨСӨВ

| № | Үйл ажиллагааны чиглэл | Зарцуулах хөрөнгө /төг/ |
|---|---|-------------------------|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 12,070,000 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 9,000,000 |
| 3 | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 4 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 1,900,000 |
| 5 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 3,500,000 |
| 6 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 1,000,000 |
| 7 | Удирдлага зохион байгуулалт | - |
| 8 | Талуудад тайлагнах хуваарь | 1,000,000 |
| | Нийт | 28,470,000 |

XIV. ХАВСРАЛТ



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000230408

2007.12.21 / Бүртгэсэн өдөр, сар, өдөр /

9011127141 / Хуулийн хэргийн дугаар /

2707349 / Регистрийн дугаар /

Бласттек / Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Дүрэм / Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр / шийдвэрийн нэр /

01 / дугаар /

2002.05.21 / өдөр, сар, өдөр /

46100 / Код /


Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй / хугацаа /


2 / хэргийн хэмжээ, мянган төгрөгөөр /

3,000,000.00 / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Хэнтий, Бор-Өндөр, 1-р баг, Бор-Өндөр, нийтийн 9, 3 тоот, Утас1: 75757979, Утас2: , Факс: 326466 / хуулийн этгээдийн аялан замын хаяг /



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
/ Бүртгэсэн байгууллагын нэр /
УЛСЫН БҮРТГЭГЧ
/тэмдэг/


З. ОНОРБАЯР
/ардын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2022 он 02 сар 08 өдөр



МОНГОЛ УЛС

АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

Дугаар: 0000128471

| | |
|---|---|
| Бласттек ХХК | 2707349 |
| <i>(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)</i> | <i>(регистрийн дугаар)</i> |
| Сумын Засаг даргын захирамж | 20 22 оны 10 сарын 13 өдрийн А/160 тоот |
| <i>(шийдвэр гаргагч)</i> | |
| шийдвэрийг үндэслэн | Хэнтий Бор-Өндөр 5-р баг Хүйх |
| <i>(аймаг, нийслэл)</i> | <i>(сум, дүүрэг) (баг, хороо)</i> |
| Үйлдвэр-1 | 115а хаягт |
| <i>(гудамжны нэр)</i> | <i>(хашгааны дугаар)</i> |
| байрлах, нэгж талбарын | 2322003619 дугаар бүхий 34185 м.кв газрыг |
| Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж | зориулалтаар |
| 15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн | Э-1804000472 |

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.



Энэхүү гэрчилгээ хүчинтэй эсэхийг QR кодыг уншуулж шалгах бөгөөд гэрчилгээнд агуулагдаж буй мэдээллийг харах боломжтой.

Хэвлэсэн огноо: 2022-10-24